

МОНГОЛ УЛСЫН ИХ СУРГУУЛЬ

ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ БИЧИГ

№ 08/293

НШУС

2008

“СЭТГҮҮЛ” ГЭДЭГ ҮГИЙН ГАРЛЫГ МӨШГӨХ НЬ

Н.Ариунзаяа*

* Сэтгүүл зүйн магистр

Түлхүүр үг: сэтгүүл тэмээ, өдөр тутам, дэвтэрлэсэн хэвлэлийн бүтээгдэхүүн, хөмрөг, эрдмийн мэдээлэл, мэдээллийн хураавар, түүвэр, эрээвэр хураавар тэмдэглэл.

Бид «сонин», «сэтгүүл», «сэтгүүл зүй» гэж байнга ярих мөртөө эдгээр үг анх хэдийд, яаж үүссэн, утга нь хэрхэн улирч хувьсаж ирснийг тухайлан сонирхож судалсан нь тийм ч элбэг биш байна. Эдгээр үгийн гарал үүслийг мэдэх нь зөвхөн үгийн төдий бус соёл, түүхийн гүнзгий учир холбогдолтой юм. Иймээс «Сэтгүүл» гэдэг үг хэрхэн үүссэн тухай товч өгүүлье.

Монголд бодит сэтгүүл зүйн уламжлалт хэрэгслийн нэг болох сэтгүүл (тогтол хугацаанд тархаадаг, мэдээллийн зориулалттай, дэвтэрлэсэн хэвлэлийн бүтээгдэхүүн) гаргаж эхэлсэн үеэс энэ үгийн хэрэглээ эрс өссөн байна. Тэгээд дав даруй оросын «Журнал» гэдэг үгийг «Сэтгүүл» хэмээн орчуулж хэрэглэсэн байдал. Оросууд Өргөн

дахинд өргөн хэрэглэгддэг «Journal» гэдэг үгийг идээшүүлэн хэрэглэсэн нь тийнхүү «журнал» болжээ. «Journal» гэдэг үг анх ("Diurnus"- "Өдөр бүрийнх") гэсэн утгатай латин үгнээс гаралтай бөгөөд 1665 онд Парис хотод хэвлэгдсэн ("Le Journal des Savans"- "Эрдэмтдийн сэтгүүл") сэтгүүл үг нэрийг анх удаа хэрэглэсэн байна.

Ерөөсөө дэлхийн улс орнууд «сэтгүүл» гэдэг үгийг янз янзаар, бас өөр өөр утгаар хэрэглэж иржээ. Өргөн дахинд «Magazine» (араб хэлний "Makhazin"- "Хөмрөг"-өөс гаралтай) гэдэг үгээр сэтгүүлийг тэмдэглэдэг. Анх францчуудын «Magasine» хэмээн бичиж хэрэглэж байсан энэ үг яваандаа англи хэлэнд оржээ. Харин Эдвард Кэйв (1691-1754) гэдэг хүн 1731 онд ("Gentlemen's Magazine"- "Томоотодын сэтгүүл")-ийг гаргахдаа энэ үгийг анх хэрэглэсэн юм. Түүнээс гадна англи хэлэнд ("Serial"- "Цуврал") гэдэг үгээр сэтгүүлийг тэмдэглэдэг. Энэ нь тогтол гардаг хэвлэлийн дэвтэрлэсэн бүтээгдэхүүний ерөнхий нэр бөгөөд түүнд

(“Magazine”-нийтэд зориулсан), (“Journal” - эрдэм шинжилгээний) гэсэн сэтгүүлийн хоёр хэлбэр багтдаг ажээ.

Дорно дахинд ч «сэтгүүл»-ийг янз янзаар нэрлэж иржээ. Жишээ нь Японд сэтгүүлийг (“Gakuhou”-“Гакухоу”-“Эрдмийн мэдээлэл”) гэдэг бөгөөд энэ нь «Journal»-тай дүйх утгаар хэрэглэсэн нэр юм. Учир нь Японы их сургуулиудад багш нарын уншсан лекцийг товхимол болгон хэвлэж тараадаг байсан бөгөөд түүнийгээ «Gakuhou» гэж нэрлэснээс үүдэлтэй ажээ. Мөн «Zassi» (Zazhi) гэдэг ёс ч бий бөгөөд Янагава Харуми гэгч хүн 1867 онд (“Seiou zassi”) гэдэг сэтгүүл гаргаж байсан мэдээ байдаг. Тэр хүн сэтгүүлийг «Мэдээллийн хураавар», «Мэдээллийн сан хөмрөг» гэсэн утгаар ойлгож байснаас ийм нэр өгсөн бололтой.

Хятадад сэтгүүлийг заадаг «Tong Jichuan», «Hui bian», «Waizazhi», «Lian xu chi», «Xue bao» гэх мэт олон нэр хэрэглэж ирсэн байна. «Waizazhi» нь аль тэртээх Сүн улсын үеийн ном зохиолд тэмдэглэгдсэн эртний уг бөгөөд «Эрээвэр хураавар тэмдэглэл» гэсэншүү утгатай уг байжээ. XVII зуунд хэрд Шанхайд сууж байсан

Английн шашны элч Жон Макгован гэдэг хүн 1862 онд «Zhong waizazhi» гэдэг сар тутмын сэтгүүлдээ «Waizazhi» гэдэг үгийг анх хэрэглэсэн гэдэг. Тэрхүү «Waizazhi» нь английн «Miscellany»-«Түүвэр» гэдэг үтгэй утга дүйж байсан учраас тийнхүү нэрлэсэн ажээ. «Xue bao» нь японы «Gakuhou» гэдэг үгийн шууд орчуулга бөгөөд «Эрдэм шинжилгээний сэтгүүл» гэсэн утгатай юм. «Lian xu chi» нь «Serial»-аас зээлсэн «Цуврал хэвлэл» гэсэн утгатай уг болно.

Харин «Tong Jichuan», «Hui bian» гэсэн угс нь Европын улсуудад гарч байсан сэтгүүлийн хэлбэр бүхий хэвлэлийн бүтээгдэхүүн XIX зууны эцсээр Манж дайчин улсад нэвтрэх үед гарсан хятад угс ажээ.

«Сэтгүүл» гэдэг үгийг улс үндэстнүүд хэрхэн хэрэглэж ирсний зах зухаас бид товч өгүүллээ. Гэтэл монголчууд «Сэтгүүл» гэдэг үгийг хэдийнээс мэддэг байсан бэ, ялангуяа тогтол мол гардаг хэвлэлийн бүтээгдэхүүн гэдэг утгаар нь хэзээнээс хэрэглэж заншсан бэ, үгийн утга хэрхэн хувирч өөрчлөгджэх ирсэн бэ? гэсэн асуултанд хариу өгөх нь хамгаас чухал юм.

Дэлхийн улс орнууд «сэтгүүл» гэдэг үгийг янз янзаар, бас өөр өөр утгаар хэрэглэж иржээ. Орио дахинд «Magazine» (араб хэлний “Ma-khazin”-“Хомрөг”-өөс гаралтай) гэдэг угсээр сэтгүүлийг тэмдэглэдэг. Аих француудын «Magasine» хэмээн би-чижэх хэрэглэж байсан энэ уг яваандaa англи хэлэнд оржээ. Харин Эдвард Кэйв 1731 онд “Gentlemen’s Magazine”-ийг гаргахдаа энэ үгийг аих хэрэглэсэн юм.

»

«

Ойрын жишээнээс эхэлье. Монголд сэтгүүл зүй үүсэн хөгжикж эхэлмэгц оросоос «Журнал» гэдэг үгийг «Сэтгүүл» гэж орчуулж хэрэглэсэн тухай дээр цулас дурдсан. Гэтэл түүнээс өмнө 1911 оны 8 дугаар сараас Бээжинд сар тутам гарч эхэлсэн «Монгол өр үгийн сэтгүүл», 1912 оноос гарч эхэлсэн «Ихэд нийтлэх монгол бичгийн сэтгүүл»-үүдэд «Сэтгүүл» гэдэг үгийг өнөөгийн утгаар нь анх хэрэглэсэн бололтой байна. Энэ үеийг хүртэл тогтмол гардаг хэвлэлийн дэвтэрлэсэн бүтээгдэхүүнийг «Бодорол», «Дармал», «Илтгэл» гэх мэтээр нэрлэж байжээ. Тухайлбал «Монгол үгийн бодорол» (Гирин. 1908), «Монгол үгийн илтгэл» (Нанжин. 1929) зэргийг дурдаж болно. Энэ бүхэн бол зөвхөн «Сэтгүүл» хэмээх хэвлэлийн бүтээгдэхүүнийг нэршүүлэх оролдлого байв.

Tэгвэл «сэтгүүл» гэдэг үг хэзээ, хаанаас гарав? Ийм үгийг монгол хүн нэн эртнээс мэддэг байсан бөгөөд өргөн хэрэглэж байжээ. Үүнийг Дорно дахины зарим хэлний даягт тэмдэглэсэн тайлбар хийгээд эрдэмтэн Шинэтгэ, Төгсбаяр нарын бичсэн өгүүллүүдээс залган авч мөшгөн тайлбарлахыг хичээе.

Нэг. «Сэтгүүл» гэдэг үг монголчуудын мэдээллийн харилцаанд хэрэглэгдэж байсан эртний үг бөгөөд мэдээлэл дамжуулах хэрэгсэлд гарсан өөрчлөлттэй холбогdon нэг хэсэг мартагдаж байгаад өнгөрсөн зууны эхээр сэргэсэн

бололтой байна. Монголчууд эрт дээр үеэс «сэтгүүл» гэдэг үгийг хэрэглэж асан хийгээд утга нь өнөөгийн «сэтгүүл»-тэй ойролцоо байсныг хуучин ном зохиол, ялангуяа толь бичгүүд бидэнд хэлж өгч байна. XVIII зууны эхэн үед зохиогдсон «Хорин нэгт» хэмээх тайлбар тольд «Цэргийн хэрэгт довтлох хүмүүнийг сэтгүүл хэмээмүй», «Дайсныг дарсан баярын мэдээг дээр сонсгон айлтгахыг сэтгүүл довтолгомуй хэмээмүй» гэжээ. Уг толтый нэгэн үеийн бүтээл болох «Манж үгийн таван хэлний толь»-д «Serkin»-“сэтгүүл” (хэрэг заргын зүйл), «Serkin»-“сэтгүүлч” (хүний зүйл), «Serkin weksibumbi»-“сэтгүүл довтолгомуй” (байлдах, дийлэх зүйл) гэсэн үгс байна. 1925 онд мөнхүү Таван хэлний толиос зөвхөн монгол-хятад үгийг түүж эмхтгэсэн Тэмгэтийн толь болон «Монгол-хятад-манж үсгийн Сан хэ»-д “Сэтгүүл”, “Сэтгүүл довтолгомуй” гэсэн үгнүүд гардаг.

«Манж-япон толь»-д “сэтгүүл”-тэй ижил утгатай үгсийг (“Serki”- Цэргийн мэдээ зэргийг довтлон мэдээлэх хүн), (“Serki weksibumbi”-Ялалтыг мэдээлэх, ялалт мэдээлэх хүнийг довтолгох), (“Serkin”-Өртөөгөөр дам дамаар хүргэх дээрхийн зарлиг эвхмэл зэргийн зүйл) хэмээн тайлбарласан байна.

БНХАУ-ын Өвөрモンголын Их Сургуулийн профессор Төгсбаяр «Сэтгүүл» нь анхандаа мэдээ хүргэх онц эрхтэй ажлын хүнийг зааж байснаа аяндаа тухайн хүний авч явдаг эвхмэл

буюу бичгийн мэдээг ч мөн тэгэж нэрлэх болсон ажээ» гэсэн дүгнэлт хийжээ. Харин эрдэмтэн Шинэтгэ «Сэтгүүл» гэх монгол үгэнд хааны зарлиг ба цэргийн албан хэргийг довтолгон мэдүүлэгч, мөн тэр тухай чухал мэдээ гэх хоёр утгатай байсан бөгөөд түрүүчийн утга нь гол болж байжээ» гэсэн байна. Үүнээс үзвэл «сэтгүүл» гэдэг үг нь анхандаа мэдээ хүргэдэг хүнийг зааж байжээ.

Хоёр. XX зууны дөчөөд онд Дэмчигдонров вангийн зохиосон толь бичигт «Сэтгүүл»-Олонд тархаан мэдээ өгөх бичгийн нэр буюу, бас цэргийн хэрэгт довтлохыг сэтгүүл хэмээмүй» гэсэн байна. Үүнээс үзвэл мэдээ хүргэдэг хүнийг зааж байсан «сэтгүүл» гэдэг үг яваандаа тэр хүний авч яваа мэдээний бичгийг заах болжээ. Өнгөрсөн зууны эхний хагаст зохиогдсон монгол хэлний толь бичгүүдэд тэрхүү утгын шилжилтийг тусгасан байдаг. Тухайлбал нэrt бичгийн хүн Шагжийн «Эрэхүйеэ хялбар болгон зохиосон монгол үгний тайлбар - Чандманийн эрхи» хэмээх тольд «Сэтгүүл»-Цэргийн хэрэгт довтлох хүнийг, бас урьдын цагт аливаа буулгасан зарлиг, айлтгах хэргийг өртөөгөөр хүргүүлэхийг, бас эдүгээ Засгийн газар ба Нам, Залуучуудын эвлэлийн Төв Хорооноос дармал даран давхин гаргаж тархаах бичгийн нэр» гэсэн бол «Сэтгүүл довтолгомуй»-Байлдааны газраас дайсныг дарсан баярын мэдээг дээш

сонсгон айлтгахуй» гэсэн байна. Дээрх тайлбараас «...дармал даран давхин гаргаж тархаах бичгийн нэр» гэсэн үг анхаарал татаж байна. Эртдээ зарлиг, айлтгал, мэдээ зэргийг амаар болон бичгээр тархаадаг хүнийг хэлж байснаа, хожим дармал дарж хэвлэлийн аргаар бүтээсэн бичгийн нэр болсон нь өнөөгийн шуудангаар тардаг «сэтгүүл»-ийг заах тийш улам бүр ойртоны баримт юм.

Гувал. Монгол толь бичгүүдэд «Сэтгүүл тэмээ» гэдэг үг байдаг. Тэр нь өнөөгийн «сэтгүүл» гэдэг үгтэй холбогдох уу, үгүй юу, холбогдовол ямар шижмээр холбогдох вэ? гэдэг нь их сонин асуулт юм. Өнгөрсөн зууны гuchaад онд зохиогдсон Шагжийн тольд «Сэтгүүл тэмээ»: Хэвтвээс хэвллий газарт хүрэхгүй, нэгэн өдөр мянган газар явбаас болох тэмээний нэр, сэтгүүл довтолгохуйд хэрэглэх тул ийн нэрлэжээ» гэсэн байна. Профессор Төгсбаяр энэ тайлбар зөв боловч шалтгаан, үр хоёрыг тонгоруулсан учир зүйн алдаатай болохыг дурдаад «Сэтгүүл довтлоход тэмээ унаснаас сая тэр тэмээг «сэтгүүл тэмээ» гэсэн бус, харин бачим мэдээ хүргэхэд хөл хурдан «сэтгүүл тэмээ»-г унаснаас сая «сэтгүүл довтолгох» гэдэг үг үүссэн байх ёстой» гээд энэ үг анх Монгол лугаа угсаа гарал нэгтэй табгач хүний байгуулсан Умард Вэй улсын үед тэмдэглэгдсэнийг сийрүүлэн мэдээлсэн байна. Тэр нь тухайн үеийн «Мулганы

дуу» (*mulange*) юм. Тэр дуунд дайнаас буцахыг бичихдээ:

«Буцаж ирээд тэнгэрлэг эзэн лүгээ золгохуйяа

Богд эзэн тоонот өргөөндөө авай

Гавьяа тэмдэглэж арван хоёронтаа давшуулруун

Ганц соёрхолдоо мянган түмнээр хүртүүлбэй

Хаан бээр надаас юуг хүсмүй хэмээн асуулаа

(Харц би бээр хэргэм зэргийг хүсэхгүй

Хилэн тавагт сэтгүүл тэмээгээ унуулаад

Хөвгүүн намайг нутагт минь илгээмын хэмээмүй») гэсэн байжээ. Энэ мэдээ бол «сэтгүүл», «сэтгүүл тэмээ» гэдэг үгс эрт үүссэн болохыг гэрчилж байгаа бодитой баримт мөн.

Профессор Төгсбаяр «сэтгүүл тэмээ» гэдэг эртний үгийн үүссэн цаг үе, утгын хувиралтыг харуулах хэд хэдэн чухал эх сурвалжийг мэдээлсэн байна. Түүний олж үзсэнээр Тан улсын Дуань цэншигийн «Еү Ян цэ цу» гэдэг номонд «Тэмээний араншин нь ичимтгий» гэсэн бол «Мулганы хуудас»-нд «Сэтгүүл тэмээ», «хилэн таваг» хэмээхүйг олонх нь андуурч «Яншаа» (тэмээ) хэмээмүй. (Тэр) тэмээ хэвтвээс хэвллий нь газарт хүрэлцэхгүй, хөлөө хумиваас гэрэл сэтгэн (нэвт, нэвтрэн) харагдахуй, мянган газар явмуй» гэсэн байдаг ажээ. Тэрбээр бас Өмнөд Сүнгийн Ян

юй, Мин улсын Ян шэн нар «сэтгүүл тэмээ»-ний тухай дурдан бичиж байсныг цохон тэмдэглэсэн юм. Түүний олж үзсэнээр Мин улсын Ян шэн (1488-1559) бээр «Шэн ань-ий шулгийн үг»-дээ Дуань цэншигийн тайлбарыг давтан бичээд «Түүвэр сэтгүүл тэмээ» гэснийг онцлон дурдаж, уг зохиолд «Тангийн ёсон болбаас өртөөнөө сэтгүүл тэмээт элчийг талбиж баймуй. Хил боомтын цэргийн чухал (учир) үгүй болбаас (тэр элчийг) зоригоороо томилж үл болмуй. Ян бижи (Ян хүй пей) хатан бээр далдуур сэтгүүл тэмээт элчийг довтолгон Ан лу шань-д бэржгэр луугийн нүд хайралбай. (Тэр учир) үлгэрт харагдмуй» гэсэн байдаг ажээ. Үлгэр гэдэг нь Сүн улсын Юайши (930-1007)-гийн «Ян дэй жэн-гийн гадаад намтар»-ыг хэлсэн ажээ. Түүнд «Дээр эзэн Бижи хатандаа бэлгээ луугийн тархи (?) арвыг хайрлахуйяа Бижи бээр сэмээр сэтгүүл тэмээт элчийг довтолгож Сан лу шань-д гурвуыг нь бариулж хүргэвэй» гэж буй гэнэ. Төгсбаяр профессор энэ бүх баримтыг үндэслэн «Сэтгүүл» гэдэг нь их эртдээ хурдан тэмээг хэлж байжээ» гэсэн дүгнэлт хийсэн байна.

Дөрөв. Сэтгүүлтэй холбогдох өөр нэг үг бол «Хилэн таваг» юм. Энэ үг бас эрт үүсчээ. Дэмчигдонров вангийн тольд «Сэтгүүл тэмээ»: Энэ тэмээ хэвтвээс хэвллий нь газарт хүрэхгүй, нэгэн өдөр мянган газар явбаас болмуй. Бас хилэн таваг хэмээмүй»

гэжээ. Хурдан тэмээг хилэн гөрөөстэй адилтгасан үг бололтой. Эртний сурвалжуудад «Хилэн гөрөөс Чингис хаанд тэнгэрийн санааг дамжуулсан» гэдэг домог байдаг билээ. Энэ тухайд профессор Төгсбаяр монголчууд тэмээг эрхэмлэж «Барс тавагтай» гэхчилэн элдэв амьтны шинжийг тохиж ярьdag уламжлалтай

байсныг дурдаад «Хилэн таваг» гэдэг нь лав «хурдан шидтэй тэмээ» гэсэн санааг илтгэх гэснээс үүссэн байх гэсэн таамаглал дэвшүүлсэн нь дэмжих болохуйц санаа юм. Нөгөө талаар бас таваг (тавхай)-тай л болохоос биш хилэн гөрөөс шиг хурдан тэмээ гэсэн утга байж болно.

«Сэтгүүл тэмээ» буюу хурдан тэмээний шинжийг заахдаа «хэвтвээс хэвлэй нь газарт хүрэхгүй» гэсэн нь яаж ч бодсон малчин ардын олон мянган жилийн ажиглалтын үр дүн байж таарна. Бодвоос тийм хурдан тэмээний хөл их урт байсан болов уу! Бид хэвтсэн тэмээг ажиглахад эвхсэн урд хөл нь өвчүүний хормой орчимд, хойт хөл нь нимгэн цавины урд хэсэгт байрлах бөгөөд хэвлэй нь газарт лавтай хүрсэн байдаг. Тэгвэл сэтгүүл тэмээний хөл

ердийн тэмээнийхээс урт тул хэвлийг газраас хөндийрүүлэн завсраар нь гэрэл сэтгэдэг (тусдаг) байсан болов уу гэж бодогдоно. Бас манай малчин ардууд хурдан тэмээний хошуу шөмбөгөр, бие зэгзгэр, хөл урт хэмээн хэлэлцдэг. Нөгөө талаар монголчууд их эртдээ тэмээг элчийн харилцаанд хэрэглэдэг байсан бөгөөд хожим мориор довтолгох болсноос «сэтгүүл тэмээ» гэдэг үгийн идэвхитэй хэрэглээ багасч, зөвхөн хуучин толь бичгүүдэд тэмдэглэгдэн үлдсэн бололтой байна.

Тав. Шинэтгэгүй «"Сэтгүүл" хэмээх үгийн тухай» гэдэг өгүүлэлдээ нэг чухал санааг дурдах төдий өнгөрсөн нь «сэтгүүл» гэдэг үгийн гарал ба өнө эртний болоод орчин цагийн утгыг мөшгөхөд тустай болжээ. Тэрбээр «"Сэтгүүл" гэдэг үгийн гарал нь "сэтгэ" - (сэдхи-сэдхил-сэтгэл), "сэдхэ" - (сэдхэгүр-сэтгүүр) гэх зэрэг үгийн бүтэцтэй хавьтах тал байх авч утга болон хэрэглээний хувьд харин холбогдон бодогдохуйц юм санаанд товхийтэл буухгүй байна» гэжээ. Сэтгэн бодохын «сэтгэх» нь «сэтгүүл»-тэй ямарч холбоогүй гэдгийг итгэлтэй

«

Монголд 1913 онд сэтгүүл зүй үүсэхдээ сониноор эх сууриа тавьжсээ. Түүнээс арван жилийн дараа буюу 1923 онд «Монгол ардын нам», «Манай зам» зэрэг тогтолцол хугацаат, дэвтэрлэсэн хэвлэлийн бүтээгдэхүүн гаргасныгаа «журнал» гэдэг үгийг шууд орчуулан нэрийүүлсэн болохоос биш, эрт үед элч довтолгойж мэдээ чимээ дамжуулахад хэрэглэж байсан хурдан «сэтгүүл тэмээ»-ний нэрийг уламжлан авсан хэрэг арай биш байх.

»

гэрсөн нь «сэтгүүл» гэдэг үгийн гарал ба өнө эртний болоод орчин цагийн утгыг мөшгөхөд тустай болжээ. Тэрбээр «"Сэтгүүл" гэдэг үгийн гарал нь "сэтгэ" - (сэдхи-сэдхил-сэтгэл), "сэдхэ" - (сэдхэгүр-сэтгүүр) гэх зэрэг үгийн бүтэцтэй хавьтах тал байх авч утга болон хэрэглээний хувьд харин холбогдон бодогдохуйц юм санаанд товхийтэл буухгүй байна» гэжээ. Сэтгэн бодохын «сэтгэх» нь «сэтгүүл»-тэй ямарч холбоогүй гэдгийг итгэлтэй

хэлж болно. Харин бөглөрснийг ухаж сэтгэхийн «сэтгэх» нь бидний мөшгөж байгаа үгийн улирсан хийгээд орчилжсон утгатай гүнзгий холбоотой байгааг үгүйсгэж болохгүй.

«Сэтгүүл» гэдэг үгэнд аливаа бөглөрч тагларсан зүйл (гаанс, данхны цорго)-ийг сэтгэж онгойлгох, эсвэл мэдэх, хүрэхэд саад болж байгаа (хэрэм, хаалт) мэт зүйлийг “нэвтлэх”, мэдэгдээгүй, далд нууц юмны гүн рүү “нэвтрэх” гэсэн утга урьд үед ч байжээ. Эрдэмтэн Лессингийн «Монгол-англи толь»-д “sedgy-сэтгэх” гэдэг үйл үгийг (“To carry dispatches, messages”-бачим захиаг хүргэх, мэдээ) гэж тайлбарлажээ. Тийм бачим захиаг хүргэхэд элдэв саад бэрхшээлийг туулж, бололцоотой нүх сүвийг сэтгэн дайсанд олзлогдолгүй нэвтрэх шаардлага гардгаас мэдээ хүргэхийг «сэтгэх», мэдээ хүргэдэг хүнийг «сэтгүүл» гэсэн хэрэг. XVII зууны үеийн нэгэн монгол сурвалжид «Хусой Тавнан цэрэг дээрээс хоёр хүнийг нууж сэтгүүлэн Даян хаанаа хэл илгээнээр...» гэж гардаг нь хэл мэдээ хүргэх, нэвтрүүлэхийг «сэтгэх» гэдэг байсныг гэрчлэх юм. Өөрөөр хэлбэл «хүргэх», «сэтгэх», «нэвтлэх» гэдэг үгс ойролцоо утгатай байжээ.

Зургаа. Бөглөрсэн хийгээд учир битүүлэг юмыг ухаж сэтгэх утгыг заадаг «сэтгэх» гэдэг үйл үгнээс үүссэн «сэтгүүр» хэмээх нэр өнөөгийн сэтгүүл зүйн агуулга, мөн чанарт гойд нийцэж байгаа нь

сонирхолтой юм. Монголд 1913 онд жинхэнэ сэтгүүл зүй үүсэхдээ сониноор эх сууриа тавьжээ. Түүнээс арван жилийн дараа буюу 1923 онд «Монгол ардын нам», «Манай зам» зэрэг тогтолцом хугацаат, дэвтэрлэсэн хэвлэлийн бүтээгдэхүүн гаргасныгаа дээр өгүүлсэнчлэн «журнал» гэдэг үгийг шууд орчуулан нэршүүлсэн болохоос биш, эрт үед элч довтолгож мэдээ чимээ дамжуулахад хэрэглэж байсан хурдан «сэтгүүл тэмээ»-ний нэрийг уламжлан авсан хэрэг арай биш байх. Бас сэтгүүл бол юмны учир начрыг сэтгэж төхөж олох, нууц далд юмны гүнд нэвтрэн орох хэрэгсэл мөн гэдэг утгаар бүр ч хэрэглээгүй байх. Тэгэвч «сэтгүүл» гэдэг үгийн орчилжсон утга нь эрт үед хэрэглэгдэж байгаад мартагдсан утгатайгаа үндсэндээ дүйж байгааг монгол хүний танин мэдэхүйн сэтгэлгээний залгамж чанартай холбож үзэхээс өөр аргагүйд хүрнэ. Бид нам, төрөөс олон түмнийг удирдан чиглүүлдэг сэтгүүл зүйгээс төр засаг, эрхтэн дархтанг хянадаг сэтгүүл зүйд шилжээд байгаа билээ. Тэрхүү шинэ, чөлөөт ардчилсан сэтгүүл зүйн үр нөлөө бүхий чиглэлийн нэг нь эрэн сурвалжлах (мөшгөх) сэтгүүл зүй мөн. Энэ нь эрх дэрхтан хийгээд эд хөрөнгөөр баялаг хүмүүс жирийн ард иргэдийн эрх ашигт харшилсан аливаа үйлдэл хийхээс сэргийлж, тийм үйлдэл гарсан бол мөрөөр нь мөшгөж, ухаж сэтгэж, үнэнийг олж тогтоохыг эрхэмлэдэг

сэтгүүл зүйн чиглэл, юм. Сэтгүүл зүйн энэ шинэ чиглэлийн үйл ажиллагааны үндсэн шинж нь хурдан буюу “сэтгүүл” тэмээ шиг шуурхай, бас тийм тэмээний хэвллий доогуур гэрэл сэтгэдэг шиг шаргуу, түүнчилэн бөглөрсөн юмыг сэтгэж онгойлгодог “сэтгүүр” шиг хурц байхад оршино. Тэгэхлээр «сэтгүүл» гэдэг үгийн орчин үеийн утга нь «санаж сэтгэх»-ийн биш, харин «малтах», «төнхөх» гэдэгтэй ойролцоо утгатай «сэтгэх», «сувлэх» гэсэн агуулгатай болж хувирсан гэж хэлж болмоор санагдана.

Ашигласан бүтээлийн жагсаалт

1. «Монгол үгийн бодорол» сэтгүүл. 1908-1909. Гирин.
2. «Монгол үгийн илтгэ». Гаригийн сэтгүүл. 1929. Нанжин.
3. 1999. Монгол хэлний толь. Хөх хот.
4. Н о р о в с у р э н Л. 2000. Монголын сэтгүүл зүйн түүхэн тойм. Тэргүүн боть. УБ.
5. Н о р о в с у р э н Л. 2004. Монголын нийтлэл. Тэргүүн дэвтэр. УБ.
6. Н о р о в с у р э н Л. 2005. Сэтгүүл зүйн бичлэгийн төрөл, зүйл. УБ.
7. Р а ш нар. 1979. Хорин нэгт тайлбар толь. Хөх хот.
8. С а г а н С э ц э н. 1984. Эрдэнийн товч. Хөх хот.
9. С у й Ю а н. Монгол үсгийн хагас сарын дармал. (1929-1933).
10. Т е г с б а я р. 2002. «Сэтгүүл» гэдэг үгийн ирэлт ба түүний соёлын агуулагдац. Өвөр mongolын Их Сургуулийн ЭШБ. Хөх хот. №4.
11. Т е г с ц о г т. 1999. Монгол сонин сэтгүүлийн түүхэн тойм. Хөх хот.
12. Т э м г э т. 1956. Монгол утгын зүйл хуваасан толь бичиг. Бээжин.
13. 1994. Хорин наймт тайлбар толь. Хөх хот.
14. Ш а г ж. 1998. Монгол үгийн тайлбар толь. II хэвлэл. Бээжин.

15. Ш и н э т г э. 2001. «Сэтгүүл» хэмээх үгийн тухай. “Монгол хэл бичиг”. №4.
16. L e s s i n g D. 1960. Mongolian English Dictionary. California.
17. 2000. The American heritage dictionary of the English language. Boston, New York.

Resume

In this article, I explained about the word “setguul” and what source it originated from, how it had been used and it has been and is being used for what meanings.

As a result of all this, I ratified the word “setguul” originated from a word, which is called as “fast camel”, at fairest time and herewith, I explained about which such a camel has been used for delivering the urgent information and in later days, it has become to indicate the means of publishing the urgent information in details.